



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/37

Хэрлэн сум

Монгол хэлний талаарх төрийн бодлого,
хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2015 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан "Хэлний бодлогын Үндэсний зөвлөлийн салбарын зөвлөлийн ажиллах журам"-ын 1.3, 2.1, Аймгийн Засаг даргын 2015 оны 10 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан "Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ын 1.6, 1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Монгол хэлний талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хэлний бодлогын Үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журмын дагуу салбар зөвлөлийн нийтлэг үүргийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхийг нийт сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Нийтлэг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд газар нутаг, засаг захиргааны нэгж, гудамж, талбай, хуулийн этгээдийн нэр, хаягийг кирил болон үндэсний бичгээр хослуулан алдаагүй, зөв бичиж, 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор бүрэн байршуулахыг нийт сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Хэлний бодлогын салбар зөвлөлийн тухайн жилд харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан ажлыг тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст улирал бүр ирүүлж байхыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тазьж, өгсөн үүрэг даалгаварыг хангалтгүй биелүүлсэн сумдын Засаг дарга нарт тухай бүр хариуцлага тооцож, ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА